ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын Ерөнхий боловсролын 12 дугаар сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: СНАГ-2023/172/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br><br>Чойбалсан хот<br>2023 он | Дорнод аймаг дахьТөрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: И.Сэмжидмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор: Д.Нармандах<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Ари файнэнс аудит” ХХК<br>Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2023.02.24 № 210

танай ____________ -ны № ______________ -т

ХАЛХГОЛ СУМЫН
12 ЖИЛИЙН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.УРАНТОГОС ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын 12 жилийн сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын 12 жилийн сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсрол шинжлэх ухааны яам 2022 оноос эхлэн төсвийн шинэчлэлийн хүрээнд төрийн үйлчилгээний чанар , хүртээмжийг сайжруулах, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор чанар, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр Улсын төсвийн хуваарь болон санхүүжилт БШУЯ, БЕГ-аас шууд хуваарилагдан хянагдаж ирдэг болсон байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд боловсролын байгууллагыг үйл ажиллагааны үр дүн, чанар, гүйцэтгэл, сургалтын хөтөлбөрийн бодит өртөгт суурилсан хувьсах зардлаар санхүүжүүлэх, суралцагчийн сурлагын чанарыг хараат бусаар үнэлэх, багшийн ажлын үр дүнг суралцагчийн сурлагын чанартай уялдуулж үнэлэх, үр дүн, бүтээмжид суурилсан цалин хөлсний бодлого хэрэгжүүлэхэд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудыг шинэчлэн баталж, мөрдүүлсэн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

**Бусад асуудлын хэсэг**

Мэдээллийн технологийн бодлогын хэрэгжилтийг хангах, мэдээллийн сан бүрдүүлэх, статистик мэдээ гаргах, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зорилгоор энэ хичээлийн жилээс Боловсролын нэгдсэн мэдээллийн систем /esis/-ийн бүх үйл ажиллагаа тухайлбал: багш ажилтан, ажилчдын өөрчлөгдсөн цалин, бусад нэмэгдлүүд,

011020190

холбоо барих мэдээлэл, байршил, үндэсний болон орон нутгийн сургалтад хамрагдсан байдал, сурагчдын үнэлгээ, харьяалал, байршил, асран хамгаалагчийн мэдээлэл, багш нарын цахим журналын шинэчлэл, санхүү, хөрөнгийн мэдээлэл, статистик мэдээлэл зэрэг үйлдлүүд шинэчлэгдэн өөрчлөгдсөнтэй холбогдуулан зохих журам тушаал, шийдвэрийн дагуу цаг хугацаанд нь мэдээллийг оруулснаар мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Энэ нь БШУЯ болон бусад яамдуудын мэдээллийн эх үүсвэр болон ашиглагдаж байгаагаараа онцлог байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон* */төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **111,649,066.81** | **250,255,453.87** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 125,784,391.21 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 125,784,391.21 |
| **3121** | **Төгрөг** | - | 125,784,391.21 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 125,784,391.21 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 111,649,066.81 | 124,471,062.66 |
| **351** | **Түүхий эд материал** | 20,108,103.00 | 24,777,420.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 18,737,003.00 | 24,191,820.00 |
| 35130 | Эм боох материал | 1,371,100.00 | 585,600.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 91,540,963.81 | 99,693,642.66 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,056,500.00 | 1,424,550.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 79,982,135.74 | 87,766,764.59 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 10,502,328.07 | 10,502,328.07 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **9,063,395,735.46** | **8,908,042,714.39** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 9,063,395,735.46 | 8,908,042,714.39 |
| **392** | **Биет хөрөнгө** | 8,913,395,735.46 | 8,758,042,714.39 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 9,057,088,151.32 | 9,057,088,151.32 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (422,295,435.92) | (619,439,279.24) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 13,300,000.00 | 13,300,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (13,300,000.00) | (13,300,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 154,095,837.30 | 203,732,942.30 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (78,248,394.35) | (89,735,998.70) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 159,808,242.09 | 177,537,393.29 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (66,201,247.90) | (80,098,452.38) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 205,818,939.00 | 205,818,939.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (96,670,356.08) | (99,076,382.20) |
| 39217 | Ном | - | 2,215,401.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 150,000,000.00 | 150,000,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 150,000,000.00 | 150,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **9,175,044,802.27** | **9,158,298,168.26** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **9,175,044,802.27** | **9,158,298,168.26** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 9,175,044,802.27 | 9,158,298,168.26 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 521,977,813.50 | 521,977,813.50 |
| 51101 | Өмч: - төрийн | 521,977,813.50 | 521,977,813.50 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 7,226,870,656.26 | 7,210,124,022.25 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 7,458,283,718.25 | (1,936,512,342.01) |

| | | | |
|---|---|---|---|
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (231,413,061.99) | 9,146,636,364.26 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,426,196,332.51 | 1,426,196,332.51 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **9,175,044,802.27** | **9,158,298,168.26** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 767,672,616.64 | 10,327,370,212.27 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 7,055,364.64 | 9,237,003,944.27 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 7,055,364.64 | 9,237,003,944.27 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 7,055,364.64 | 4,303,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | | 4,303,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | | 9,112,153,360.46 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | | 120,547,583.81 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 760,617,252.00 | 1,094,669,268.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 644,397,800.00 | 939,854,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 939,854,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 644,397,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,066,152.00 | 4,498,368.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,842,652.00 | 4,498,368.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,223,500.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 109,153,300.00 | 146,013,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 109,153,300.00 | 146,013,000.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 999,085,678.63 | 1,180,663,848.33 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 999,085,678.63 | 1,180,663,848.33 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 973,360,579.16 | 1,127,504,302.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 531,967,512.53 | 644,766,155.36 |
| 210101 | Үндсэн цалин | 407,326,548.87 | 507,475,211.38 |
| 210102 | Нэмэгдэл | 83,738,906.72 | 115,894,218.00 |
| 210104 | Урамшуулал | 40,902,056.94 | 21,396,725.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 70,638,646.00 | 81,294,497.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,891,688.16 | 56,067,940.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,537,013.38 | 6,600,682.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,271,406.76 | 5,144,796.98 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 994,026.30 | 1,225,552.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,944,511.40 | 12,255,525.73 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 105,653,300.00 | 92,331,241.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,609,900.00 | 15,942,741.67 |
| 210302 | Түлш, халаалт | 84,543,400.00 | 73,011,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | 3,377,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 15,060,985.00 | 20,019,321.15 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,924,862.00 | 8,418,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 796,700.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 166,900.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,672,523.00 | 11,601,271.15 |
| 2105 | Нормативт зардал | 12,035,976.00 | 34,580,896.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 516,866.00 | 785,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,519,110.00 | 33,795,396.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 176,000.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 176,000.00 | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 610,000.00 | 2,200,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 250,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 2,200,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 237,218,159.63 | 252,303,840.39 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 11,852,500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,000.00 | 8,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 237,194,159.63 | 240,443,340.39 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 25,725,099.47 | 53,167,896.33 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 19,419,878.00 | 49,999,613.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 10,244,510.00 | 45,501,245.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,498,368.00 | 4,498,368.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,677,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,305,221.47 | 3,168,283.33 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,305,221.47 | 3,168,283.33 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | (231,413,061.99) | 9,146,706,363.94 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 69,999.68 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 69,999.68 |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (69,999.68) |
| 8 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | (231,413,061.99) | 9,146,636,364.26 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон* */төгрөгөөр/*

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 760,617,252.00 | 1,094,669,268.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 4,303,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | | 4,303,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | | 4,303,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 4,303,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 760,617,252.00 | 1,090,366,268.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 644,397,800.00 | 939,854,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 939,854,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 644,397,800.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 7,066,152.00 | 4,498,368.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,842,652.00 | 4,498,368.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,223,500.00 | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 109,153,300.00 | 146,013,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 109,153,300.00 | 146,013,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 760,617,252.00 | 944,143,986.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 760,617,252.00 | 944,143,986.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 733,307,452.53 | 890,790,615.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 531,967,512.53 | 644,766,155.36 |
| 210101 | Үндсэн цалин | 407,326,548.87 | 507,475,211.38 |
| 210102 | Нэмэгдэл | 83,738,906.72 | 115,894,218.00 |
| 210104 | Урамшуулал | 40,902,056.94 | 21,396,725.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 70,638,646.00 | 81,294,497.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 49,891,688.16 | 56,067,940.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,537,013.38 | 6,600,682.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,271,406.76 | 5,144,796.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 994,026.30 | 1,225,552.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,944,511.40 | 12,255,525.73 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 105,653,300.00 | 92,331,241.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 17,609,900.00 | 15,942,741.67 |
| 210302 | Түлш, халаалт | 84,543,400.00 | 73,011,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,500,000.00 | 3,377,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,385,784.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,252,142.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 796,700.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,500,000.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 995,500.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,841,442.00 | - |
| 2105 | Нормативт зардал | 10,218,210.00 | 33,609,921.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000.00 | - |
| 210502 | Хоол, хүнс | 9,918,210.00 | 33,609,921.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,500,000.00 | 2,090,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,500,000.00 | 2,090,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 720,000.00 | 4,675,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 360,000.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,675,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,224,000.00 | 32,023,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 21,364,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,224,000.00 | 10,658,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27,309,799.47 | 53,353,371.33 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,004,578.00 | 50,185,088.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,829,210.00 | 45,686,720.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 4,498,368.00 | 4,498,368.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,677,000.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 6,305,221.47 | 3,168,283.33 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 6,305,221.47 | 3,168,283.33 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | - | 150,525,281.21 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 24,740,890.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 24,740,890.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 24,740,890.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 24,740,890.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (24,740,890.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | 125,784,391.21 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 125,784,391.21 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон* */төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 521,977,813.50 | 1,426,196,332.51 | 7,458,283,718.25 | 0.00 | 9,406,457,864.26 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 521,977,813.50 | 1,426,196,332.51 | 7,458,283,718.25 | 0.00 | 9,406,457,864.26 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -231,413,061.99 | 0.00 | -231,413,061.99 |
| C08 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 521,977,813.50 | 1,426,196,332.51 | 7,226,870,656.26 | 0.00 | 9,175,044,802.27 |
| D01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 521,977,813.50 | 1,426,196,332.51 | 7,226,870,656.26 | 0.00 | 9,175,044,802.27 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | -9,163,382,998.27 | 0.00 | -9,163,382,998.27 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 521,977,813.50 | 1,426,196,332.51 | -1,936,512,342.01 | 0.00 | 11,661,804.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 9,146,636,364.26 | 0.00 | 9,146,636,364.26 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 521,977,813.50 | 1,426,196,332.51 | 7,210,124,022.25 | 0.00 | 9,158,298,168.26 |

## 2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,090,170,900.00 | 961,218,225.46 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,090,170,900.00 | 961,218,225.46 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,037,452,100.00 | 915,531,505.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 747,286,028.00 | 644,766,155.36 |
| 210101 | Үндсэн цалин | 560,249,217.00 | 507,475,211.38 |
| 210102 | Нэмэгдэл | 164,671,289.00 | 115,894,218.00 |
| 210104 | Урамшуулал | 22,365,522.00 | 21,396,725.98 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 92,186,547.00 | 81,294,497.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,787,275.14 | 56,067,940.15 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,386,684.67 | 6,600,682.09 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,879,107.66 | 5,144,796.98 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,466,670.93 | 1,225,552.48 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,666,808.60 | 12,255,525.73 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 92,331,241.67 | 92,331,241.67 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,942,741.67 | 15,942,741.67 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 73,011,500.00 | 73,011,500.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,377,000.00 | 3,377,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 33,791,700.00 | 33,609,921.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,791,700.00 | 33,609,921.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,258,783.33 | 2,090,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 5,258,783.33 | 2,090,500.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,105,800.00 | 4,675,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,105,800.00 | 4,675,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,492,000.00 | 56,764,190.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 48,833,300.00 | 46,105,490.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,658,700.00 | 10,658,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 52,718,800.00 | 45,686,720.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 52,718,800.00 | 45,686,720.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 52,718,800.00 | 45,686,720.00 |
| III | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,090,170,900.00 | 1,087,002,616.67 |
| 31 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 939,854,900.00 | 939,854,900.00 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 939,854,900.00 | 939,854,900.00 |
| 35 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 4,303,000.00 | 4,303,000.00 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,303,000.00 | 4,303,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 146,013,000.00 | 142,844,716.67 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 146,013,000.00 | 142,844,716.67 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 125,784,391.21 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 94,233,306.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 94,233,306.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 94233306.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 00.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 94,233,306.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 94,233,306.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 94233306.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 94,233,306.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 94,233,306.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,740.9 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 24,740.9 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

### 3.1 Албан шаардлага

**1. Худалдан авалттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Хөрөнгөтэй холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Дээд шатны байгууллагын даргын шийдвэргүйгээр хөрөнгө орлого авсан, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нягтлан бодогч нар хариуцна", 12.2. "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ", 12.2.1. "жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө" заалт; 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Эд хөрөнгийн тооллого хийгдсэний дараа хөрөнгийн тооцоог бодож, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулсан байх

**2. Зардалтай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэж 5 дугаар зүйлийн 5.1.1 Үнэн зав байх гэсэн заалтуудтай нийцээгүй, иж бүрэн, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж*: Анхан шатны баримтаар баталгаажуулж ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**4. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Зөвлөмж | | Албан шаард | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна. | 1 | - | | | | - | 1 | |
| Дээд шатны байгууллагын даргын шийдвэргүйгээр хөрөнгө орлого авсан, жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодсон акт үйлдэж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна | 1 | | | | 1 | 24,740.9 | | |
| Сурагчдын хоолны санхүүжилтийг esis.edu цахим системд сурагчдын өдөр тутмын ирцийг хөтлөн няравын тайланд бүртгэж тооцоо хийдэггүй байна. | 1 | | | | 1 | | | |
| **Дүн** | **3** | | | | **2** | **24,740.9** | **1** | |

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 25 өдөр     Дугаар 82/01 ДОА-2023/172/НА-СТА-043     Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Халхгол сумын 12 жилийн сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсөвт өртгийг үндэслэл болгохгүй шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2. “Энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс дээш төсөвт өртөгтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авахад энэ хуульд өөрөөр заагаагүй бол нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэнэ”, 17 дугаар зүйлийн 17.1. “Нээлттэй тендер шалгаруулалтын урилгыг энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу зарлан мэдээлж, сонирхогч этгээдийг тендер шалгаруулалтад оролцох тэгш боломжоор хангана”, 30.4. “Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана”, 30.4.1 “тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах”, 30.4.2 “энэ хуулийн 30.1.3, 30.1.4-т заасан нөхцөл үүссэн бөгөөд тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгаан нь зөвхөн худалдан авах бараа, ажил, үйлчилгээний тоо хэмжээ, цар хүрээтэй холбоотой бол тэдгээртэй холбогдолтой өөрчлөлтийг тендерийн баримт бичигт оруулж, хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулах”, 30.4.3 “энэ хуулийн 30.4.1, 30.4.2-т заасны дагуу явуулсан тендер шалгаруулалтын үр дүнд 30.1-д заасан нөхцөл байдал дахин үүсвэл шууд гэрээ байгуулах”, 34 дүгээр зүйлийн 34.3 “Энэ хуулийн 34.1-д заасны дагуу гэрээ шууд байгуулсан тохиолдолд захиалагч гэрээний хувийг уг аргыг хэрэглэх болсон үндэслэлийн хамт төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “иж бүрэн байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1. “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.9 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

011040395

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, алдаа зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид, алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Халхгол сумын 12 жилийн сургуулийн захирал Д.Урантогос, нягтлан бодогч П.Оюунтулга нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АУДИТЫН МЕНЕЖЕР И.СЭМЖИДМАА

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН ЗАХИРАЛ Д. АРИУНАА